



МЭДЭЭЛЭЛ, ШУУДАН, ХАРИЛЦАА  
ХОЛБОО, ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 155

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбар дахь хөдөлгөөнт холбооны үйлчилгээний дундын дэд бүтцийг хамтран ашиглах шийдэл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Ажлын хэсгийн тайлан, үр дүнг газрын удирдлагад энэ оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ш.Батзаяат/-д даалгасугай.

ДАРГА



Д.ЖАДАМБАА

112055

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2014 оны 06 сарын 10 өдрийн 155 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга:

Ш.Батзаяат

Дэд дарга

Ажлын хэсгийн нарийн бичиг:

Б.Заяабаяр

Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

Ажлын хэсгийн гишүүд:

Г.Чинзориг

Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Н.Энхбат

Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, инновацийн хэлтсийн дарга

Ц.Одхүү

Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

Ш.Очирхүү

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албаны мэргэжилтэн

Ч.Оюунгэрэл

ХХЗХ-ны Зохицуулалтын албаны дарга

А.Лувсан-Очир

ХХЗХ-ны Радио давтамж зохицуулалт, хяналтын албаны дарга

Г.Баатаржав

"Мобиком Корпораци" ХХК-ын технологийн газрын захирал

Ш.Батжаргал

"Скайтел" ХХК-ын технологийн газрын захирал

О.Тулга


"Юнител" ХХК-ын технологийн газрын захирал

Г.Тулга

"Жи-Мобайл" ХХК-ын технологийн газрын захирал

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны  
газрын даргын 2014 оны 6 сарын 10 өдрийн  
155 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ**



Зорилго: Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбар дахь хөдөлгөөнт холбооны үйлчилгээний дундын дэд бүтцийг хамтран ашиглах техникийн шийдэл боловсруулах

Ач холбогдол: Хөдөө орон нутагт хөдөлгөөнт холбооны тасралтгүй сүлжээг бий болгож иргэдэд мэдээлэл харилцаа холбооны үйлчилгээг орон зай цаг хугацаанаас үл хамааран хүргэх

Эхлэх хугацаа: 2014.06.10 – 2014.06.20

Гүйцэтгэх ажил:

1. Хөдөлгөөнт холбооны сүлжээний технологийн болон дэд бүтцийн өнөөгийн байдалын судалгаа болон төлөвлөгөө боловсруулах
2. Хөдөлгөөнт холбооны дундын дэд бүтэц байгуулах шийдэл боловсруулах;
3. Хөдөлгөөнт холбоонд дундын дэд бүтэц ашигласнаар гарах эдийн засгийн болон үр өгөөжийн судалгаа хийх